

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2021 оны 1 дүгээр сарын 01-ий өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ий өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“МИК Холдинг” ХК, 9010001134, MSE:MIK, 11-328267
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Санхүүгийн бусад үйл ажиллагаа
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	“Мэжик Консалтинг Аудит” ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	20,709,320
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Гантулга
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт
	№1 Тайланг хавсаргав
	Орлогын тайлан
	Тайланг хавсаргав
	Өмчийн өөрчлөлтийн тайлан
	Тайланг хавсаргав
	Мөнгөн гүйлгээний тайлан
	Тайланг хавсаргав
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	№1 Дүгнэлтийг хавсаргав
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/

	Байхгүй																															
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл																															
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table border="1"> <tr> <td colspan="2">Санхүүгийн үзүүлэлтүүд</td> </tr> <tr> <td colspan="2">Ашигт ажиллагаа</td> </tr> <tr> <td>Цэвэр хүүгийн маржин (NIM) *</td> <td>2.2%</td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгийн өгөөж (ROA) *</td> <td>-3.53%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) *</td> <td>-189.29%</td> </tr> <tr> <td colspan="2">Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)</td> </tr> <tr> <td>Нийт активын өөрчлөлт</td> <td>3.9%</td> </tr> <tr> <td>Зээлийн багцын өөрчлөлт</td> <td>-4.6%</td> </tr> <tr> <td colspan="2">Хөрөнгөнд эзлэх хувь</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө</td> <td>0.1%</td> </tr> <tr> <td>Зээлийн багц/Нийт хөрөнгө</td> <td>78.3%</td> </tr> <tr> <td>ИЗББ/Нийт хөрөнгө</td> <td>74.3%</td> </tr> <tr> <td>Гадаад Бонд/Нийт хөрөнгө</td> <td>23.8%</td> </tr> <tr> <td colspan="2">Хөрвөх чадварын харьцаа</td> </tr> <tr> <td>Хөрвөх чадвартай хөрөнгө / Татан төвлөрүүлсэн хөрөнгө</td> <td>0.75%</td> </tr> </table>	Санхүүгийн үзүүлэлтүүд		Ашигт ажиллагаа		Цэвэр хүүгийн маржин (NIM) *	2.2%	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) *	-3.53%	Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) *	-189.29%	Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)		Нийт активын өөрчлөлт	3.9%	Зээлийн багцын өөрчлөлт	-4.6%	Хөрөнгөнд эзлэх хувь		Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	0.1%	Зээлийн багц/Нийт хөрөнгө	78.3%	ИЗББ/Нийт хөрөнгө	74.3%	Гадаад Бонд/Нийт хөрөнгө	23.8%	Хөрвөх чадварын харьцаа		Хөрвөх чадвартай хөрөнгө / Татан төвлөрүүлсэн хөрөнгө	0.75%
Санхүүгийн үзүүлэлтүүд																																
Ашигт ажиллагаа																																
Цэвэр хүүгийн маржин (NIM) *	2.2%																															
Нийт хөрөнгийн өгөөж (ROA) *	-3.53%																															
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) *	-189.29%																															
Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)																																
Нийт активын өөрчлөлт	3.9%																															
Зээлийн багцын өөрчлөлт	-4.6%																															
Хөрөнгөнд эзлэх хувь																																
Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	0.1%																															
Зээлийн багц/Нийт хөрөнгө	78.3%																															
ИЗББ/Нийт хөрөнгө	74.3%																															
Гадаад Бонд/Нийт хөрөнгө	23.8%																															
Хөрвөх чадварын харьцаа																																
Хөрвөх чадвартай хөрөнгө / Татан төвлөрүүлсэн хөрөнгө	0.75%																															
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																															
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Байхгүй																														
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	№2.4 Балансын гадуур үлдэгдлийн тайлан , НББ-ийн бодлого хавсаргав.																														
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд зээл аваагүй байна.																														
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/																															

	<p>“Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК Олон улсын зах зээлд бонд гаргахтай холбоотойгоор “МИК Холдинг” ХК нь баталгаа гаргаж дараах их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан байна.</p> <ol style="list-style-type: none"> 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр - Indenture (Бондын нөхцөлийн гэрээ) 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр - Purchase agreement (Худалдан авах гэрээ) 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдөр - Баталгааны гэрээ <p>“Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК дотоодын биржийн бус зах зээлд өрийн хэрэгсэл гаргахтай холбоотойгоор “МИК Холдинг” ХК нь баталгаа гаргаж дараах их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан байна.</p> <p>2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр - Баталгааны гэрээ</p>																												
4.	Цалин урамшууллын мэдээлэл																												
	<p>ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг эзэмшигчдийн хурлаас тогтоодог. ТУЗ-ийн гишүүнд олгох цалин нь суурь болон нэмэгдэл цалингаас бүрдэнэ. Суурь цалин нь ТУЗ-ийн гишүүнээс томилогдон ажиллаж байгаагийн хувьд сар болгон олгогдох тогтмол цалин бөгөөд харин нэмэгдэл цалинг хуралд оролцсон оролцоо тус бүрээр тооцогдон улирал нэг удаа олгодог.</p>																												
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл																												
	<p>Хувьцаа эзэмшигчдийн хурал</p> <p>Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Компанийн веб сайтаар дамжуулан цахим болон зайны технологи ашиглан зохион байгуулж хуралдуулсан. Хурлаар Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай, Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай, ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай, Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай гэсэн асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл ба түүний дэргэдэх хороод</p> <p>“МИК Холдинг ХК-ийн ТУЗ нь зургаан ердийн гишүүн, гурван хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатай бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд банк санхүү, хөрөнгийн зах зээлийн талаарх өргөн мэдлэг туршлагатай, ур чадвартай гишүүд ажилладаг.</p> <table border="1" data-bbox="263 1456 1495 1874"> <thead> <tr> <th>№</th> <th>Нэр</th> <th>Ажил албан тушаал</th> <th>ТУЗ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Мягмарын Мөнхбаатар</td> <td>“Азиа Дайверсифайд Рийл Истэйт Фанд Нэг” ХХК-ийн зөвлөх</td> <td>Ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга</td> </tr> <tr> <td>2</td> <td>Сэдваанчигийн Цэрэндаш</td> <td>Монгол Улсын хөгжлийн банкны бизнес хөгжил хариуцсан дэд захирал</td> <td>Ердийн гишүүн</td> </tr> <tr> <td>3</td> <td>Атарбаатарын Энхжин</td> <td>Монгол банкны Нөөцийн удирдлага санхүүгийн зах зээлийн газрын захирал</td> <td>Ердийн гишүүн</td> </tr> <tr> <td>4</td> <td>Товуудоржийн Даваажав</td> <td>Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал</td> <td>Ердийн гишүүн</td> </tr> <tr> <td>5</td> <td>Эрдэнэбилэгийн Тулга</td> <td>“Ти Ди Би Секьритис” ХХК-ийн Ерөнхийлөгч</td> <td>Ердийн гишүүн</td> </tr> <tr> <td>6</td> <td>Батцэнгэлийн Үүрцайхбаатар</td> <td>Капитрон банкны Гүйцэтгэх захирал</td> <td>Ердийн гишүүн</td> </tr> </tbody> </table>	№	Нэр	Ажил албан тушаал	ТУЗ	1	Мягмарын Мөнхбаатар	“Азиа Дайверсифайд Рийл Истэйт Фанд Нэг” ХХК-ийн зөвлөх	Ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга	2	Сэдваанчигийн Цэрэндаш	Монгол Улсын хөгжлийн банкны бизнес хөгжил хариуцсан дэд захирал	Ердийн гишүүн	3	Атарбаатарын Энхжин	Монгол банкны Нөөцийн удирдлага санхүүгийн зах зээлийн газрын захирал	Ердийн гишүүн	4	Товуудоржийн Даваажав	Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал	Ердийн гишүүн	5	Эрдэнэбилэгийн Тулга	“Ти Ди Би Секьритис” ХХК-ийн Ерөнхийлөгч	Ердийн гишүүн	6	Батцэнгэлийн Үүрцайхбаатар	Капитрон банкны Гүйцэтгэх захирал	Ердийн гишүүн
№	Нэр	Ажил албан тушаал	ТУЗ																										
1	Мягмарын Мөнхбаатар	“Азиа Дайверсифайд Рийл Истэйт Фанд Нэг” ХХК-ийн зөвлөх	Ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга																										
2	Сэдваанчигийн Цэрэндаш	Монгол Улсын хөгжлийн банкны бизнес хөгжил хариуцсан дэд захирал	Ердийн гишүүн																										
3	Атарбаатарын Энхжин	Монгол банкны Нөөцийн удирдлага санхүүгийн зах зээлийн газрын захирал	Ердийн гишүүн																										
4	Товуудоржийн Даваажав	Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал	Ердийн гишүүн																										
5	Эрдэнэбилэгийн Тулга	“Ти Ди Би Секьритис” ХХК-ийн Ерөнхийлөгч	Ердийн гишүүн																										
6	Батцэнгэлийн Үүрцайхбаатар	Капитрон банкны Гүйцэтгэх захирал	Ердийн гишүүн																										

7	Энхбаярын Шижир	Уул уурхай металлургын цогцолбор байгуулах төслийн удирдагч	Хараат бус гишүүн
8	Чулуундоржийн Хашчулуун	Монгол Улсын Их Сургуулийн Дэд профессор	Хараат бус гишүүн
9	Өлзийбаярын Ганзориг	Мандал даатгал" ХК-ийн ТУЗ-ийн дарга	Хараат бус гишүүн

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

"МИК Холдинг" ХК-ийн ТУЗ нь түүний охин компани болох "МИК ОССК" ХХК, "Протего Фэрст" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурлын бүрэн эрхийг, "МИК Рийл Эстэйт" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг, "МИК ОССК" ХХК-ийн ТУЗ нь ТЗК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг дүрэмд заасны дагуу тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

"МИК Холдинг" ХК-ийн ТУЗ нийт 13 удаа хуралдаж Компанийн засаглалын баримт бичгийг батлах, Групп Компанийн бүтцийг шинэчлэх, санхүүгийн тайланг хэлэлцэх, баталгаа гаргах, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд зарлан хуралдуулах, Компанийн бизнес төлөвлөгөө батлах зэрэг нийт 54 шийдвэр гарган ажилласан.

"МИК ОССК" ХХК-ийн ТУЗ нь нийт 14 удаа хуралдаж ТЗК үүсгэн байгуулах, үнэт цаас гаргах, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, орон сууц ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ байгуулах зэрэг нийт 24 шийдвэр гарган ажиллалаа. ажиллалаа.

ТЗК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал нийт 9 удаа хуралдаж Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, Компанийн дүрмийг шинэчилж батлах, орон сууцны зээлийн хөтөлбөрийн хүрээнд нийт 367 тэрбум төгрөгийн ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас арилжих зэрэг шийдвэрийг гаргасан.

"МИК Рийл Эстэйт" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулан хуралдуулж Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах асуудлыг хэлэлцлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

ТУЗ-ийн дэргэд Санхүү, аудитын хороо, Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо болон Эрсдэлийн удирдлагын хороо гэсэн байнгын хороод үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээр нь Компанийн засаглалын зохистой бодлого, зарчмыг хэрэгжүүлэхэд ТУЗ-д дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Санхүү аудитын хороо

ТУЗ-д удирдах чиглүүлэх болон хянан шалгаа үүргээ үр ашигтай бүтээлч хийж гүйцэтгэхэд туслах, Компанийн санхүүгийн төсөв, тайланд хяналт тавих, хөндлөнгийн аудитортай харилцан ажиллах, дотоод аудитын бодлого, журам зэргийг хангах асуудлыг хариуцан ажиллана.

Хорооны бүрэлдэхүүн:

Дарга: Э.Шижир
 Гишүүн: Т.Даваажав, Ч.Хашчулуун, Ө.Ганзориг

Нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хороо

Компанийн засаглалын тогтолцоотой холбоотой бодлого, дүрэм журам, тэдгээрийн өөрчлөлт, шинэчлэлт хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг хариуцах, ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлага болон ажлаа шууд тайлагнадаг албан тушаалтыг сонгон шалгаруулах, тавигдах шаардлагыг тодорхойлох, нэр дэвшүүлэх, тэдгээртэй байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагыг үнэлэх ажлыг зохион байгуулах асуудлыг хариуцах, мөн тэдгээрийн цалин урамшууллын бодлого, түүний хэрэгжилтэд хяналт тавих, цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд цалинг урамшууллыг олгох ажлыг зохион

	<p>байгуулдаг. Мөн Компанийн хүний нөөцийн бодлого, урамшууллын бодлогыг тодорхойлж үр дүнг үнэлэх зэргийг хариуцан ажилладаг.</p> <p>Хорооны бүрэлдэхүүн: Дарга: Ч.Хашчулуун Гишүүн: М.Мөнхбаатар, Э.Шижир, Ө.Ганзориг</p> <p>Эрсдэлийн удирдлагын хороо Эрсдэлийн бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн дээд хязгаарт хяналт тавих, бизнесийн үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлийг хянах, дүгнэх асуудлыг хариуцан ажилладаг.</p> <p>Хорооны бүрэлдэхүүн: Дарга: А.Энхжин Гишүүн: С.Цэрэндаш, Б.Үүрцайхбаатар, Э.Тулга</p>												
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл												
	<p>i. Валютын ханшийн эрсдэл</p> <p>Компани валютын ханшийн эрсдэлийн үнэлгээнд VAR аргачлалыг ашиглан, ханшийн өөрчлөлтөөс хүлээж болзошгүй алдагдал нийт өөрийн хөрөнгийн 15%-с хэтрэхгүй байх шалгуурыг тавьдаг бөгөөд сар бүр ханшийн эрсдэлийн шинжилгээг хийж, холбогдох газар нэгжүүд болон удирдлагыг мэдээллээр ханган ажиллаа. Валютын ханшийн эрсдэлийг гуравдагч этгээдэд шилжүүлэх буюу своп хэлцэл хийх байдлаар бууруулж ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд компани дээр дурдсан шалгуурыг хангаж ажилласан байна.</p> <p>ii. Хөрвөх чадварын эрсдэл</p> <p>Хөрвөх чадварын эрсдэлийг түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа болон төлбөр гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтээр хэмжиж байна. Түргэн хөрвөх хөрөнгийн харьцааг тооцохдоо ирэх 30 хоногийн нийт цэвэр гарах мөнгөн урсгалыг өндөр хөрвөх чадвартай хөрөнгөд харьцуулдаг бөгөөд уг харьцаа нь 100%-иас их байх шалгуурыг тавьж байна. МИК ОССК-ийн хувьд түргэн хөрвөх хөрөнгийн харьцааны шалгуурыг хангаж ажиллаж байгаа бөгөөд цаашид тухайн жилийн Эрсдэлийн аппетитаар тогтоосон эрсдэлийн зорилтот түвшин, анхааруулах түвшин болон дээд түвшинтэй уялдуулан хяналт тавьж ажиллахаар төлөвлөж байна.</p> <p>Төлбөр гүйцэтгэх чадварын харьцааг хөрвөх чадварын зөрүүгийн тайлан, түүний хугацааны интервалын үзүүлэлтүүдэд үндэслэнэ. Шалгуур үзүүлэлтийг нийт хугацааны интервалаарх цэвэр хөрвөх чадварын зөрүүний өсөн нэмэгдсэн дүн 0-ээс их байна гэж зааж өгсөн ба уг үзүүлэлтийг ханган ажиллаж байна.</p> <p>iii. Хүүгийн эрсдэл</p> <p>Хүүгийн эрсдэлийг хөвөгч хүүтэй актив пассивын зөрүү болон хүү олдог актив болон хүүгийн зардал гардаг пассивын зөрүүгээр тооцоолдог бөгөөд уг үзүүлэлтүүдэд сар бүр шинжилгээ хийж, холбогдох газар нэгжүүд болон удирдлагуудад мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажиллаа.</p>												
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/												
	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="240 1686 320 1765">№</th> <th data-bbox="320 1686 890 1765">Хувьцаа эзэмшигчдийн нэрс</th> <th data-bbox="890 1686 1182 1765">Хувьцааны тоо ширхэг</th> <th data-bbox="1182 1686 1437 1765">Хувь хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="240 1765 320 1809">1</td> <td data-bbox="320 1765 890 1809">Монгол Улсын хөгжлийн банк</td> <td data-bbox="890 1765 1182 1809">3,081,955</td> <td data-bbox="1182 1765 1437 1809">14.88 %</td> </tr> <tr> <td data-bbox="240 1809 320 1865">2</td> <td data-bbox="320 1809 890 1865">Си Эн Би Консалтинг ХХК</td> <td data-bbox="890 1809 1182 1865">2,608,480</td> <td data-bbox="1182 1809 1437 1865">12.60%</td> </tr> </tbody> </table>	№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Хувь хэмжээ	1	Монгол Улсын хөгжлийн банк	3,081,955	14.88 %	2	Си Эн Би Консалтинг ХХК	2,608,480	12.60%
№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Хувь хэмжээ										
1	Монгол Улсын хөгжлийн банк	3,081,955	14.88 %										
2	Си Эн Би Консалтинг ХХК	2,608,480	12.60%										

	3	Азиа Дайверсифайд Рийл Истэйт Фанд Нэг Хувийн ХОС	2,312,500	11.17%
	4	Худалдаа хөгжлийн банк	2,070,932	10.00 %
	5	“Ти Ди Би Капитал” ХХК	1,232,785	5.95%
	6	“Ти Ди Би Секьюритиз” ХХК	1,097,953	5.30 %
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл			
	Байхгүй			
9.	Ногдол ашгийн мэдээлэл			
	Компани нь олон улсын зах зээлд бонд гаргасантай холбоотой олон улсын хөрөнгө оруулагч нарын өмнө хүлээсэн үүргийн дагуу гэрээнд заасан нөхцөл болон “Ногдол ашгийн бодлого”-ын 3.3 дахь “ТУЗ-ийн шийдвэрээр тодорхой хугацаанд ногдол ашиг хуваарилахгүй байж болно” гэсэн заалтыг үндэслэн ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.			
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл			
	<p>i. Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасаг /УНТЭ/</p> <p>Улсын Нэгдүгээр Төв эмнэлэг /УНТЭ/-ийн дөрвөн давхрын "Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгийн ламинар урсгалтай хагалгааны өрөө"-ний тохижилтын ажлыг "МИК ОССК" ХХК ивээн тэтгэж нийгмийн хариуцлагын хэрэгжүүлэн ажиллаа.</p> <p>ii. Явган, авто замын тохижуулалт</p> <p>МИК нь нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд өөрийн зардлаар нийтийн эзэмшлийн 268 м2 явган зам, авто замын хашлагыг бүрэн шинэчилж, 128.5 м2 нийтийн эзэмшлийн зогсоолыг холбогдох зөвшөөрлийн дагуу явган зорчих зориулалттай зам болгон бүрэн засварлаж цэцгийн мандал, сандал зэргийг байршуулан тохижилтыг хийв. Мөн Компанийн эргэн тойронд 40 м2 талбайд мод, ногоон ургамал тарьж, орчны гэрэлтүүлгийг хийсэн.</p> <p>iii. КОВИД-19</p> <p>МИК нь нийгмийн хариуцлагын хүрээнд КОВИД-19 цар тахлаас сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор ажилтнуудыг. Халдвараас сэргийлэх, тархалтыг зогсоох, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа хаасан үед хүүхэд асрах боломжийг бүрдүүлэх зорилгоор ажилтнуудаа гэрээс буюу зайнаас ажиллуулах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлэв. Мөн ажлын байранд халуун хэмжигчтэй ариутгагч хаалгыг байршуулж, ажлын байранд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, нийт ажилтнуудыг амны хаалт, гар ариутгагч болон бусад ариутгалын бүтээгдэхүүнээр тогтмол хангахын зэрэгцээ ажилтнууддаа дархлаа дэмжигч эрүүл мэндийг багцыг хүргүүлэв.</p>			
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:				

Овог, нэр: Б.Гантулга

Албан тушаал: "МИК Холдинг" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Саруул

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

★★★ АЛБАНЫ НУУЦ